


ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН МЭДЭЭЛЭЛ, ХУВЬЦААНЫ ЭРГЭЛТ

“Нако түлш” ХК нь 2007 онд 11 сарын 29-нд 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 11 сая ширхэг хувьцааг СЗХ бүртгүүлсэн билээ.

- 2010 оны 3 сарын 31-ний байдлаар нийт 104 хувьцаа эзэмшигчтэй байна.
- Нийт хувьцаанаас 5-аас дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчдийг харуулвал:

Хувьцаа эзэмшигчид	Хувьцааны тоо ширхэг	Нийт хувьцаанд эзлэх хувь
Firebird Global Master Fund	3'305'000	30%
Firebird Global Master Fund II	2'685'000	24.41%
“Эм И Ти Эф” ХХК	1'000'000	9.09%
Firebird Mongolia fund	880'000	8%
“БиДиСЕК” ХК	1,864,528	16.95%

Хувьцааны арилжаалагдсан байдал болон үнийн хэлбэлзэлийг графикаас харна уу.



“Нако түлш” ХК-ийн хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжаа 2008 оны 7 сарын 14 өдөр эхэлсэн. Хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээс хойш 2009 оны 9 сарын 15-ны өдөр хүртэл нийт 5'741'022 ширхэг буюу 52.19%, 2010 оны 3 сарын 23-ны өдөр хүртэл нийт 7'888'689 ширхэг хувьцаа буюу нийт хувьцааны 71.72% нь арилжаалагдсан байна. Нийт арилжаалагдсан хувьцааны дундаж ханш нь 238 төгрөг, доод үнэ 115 төгрөг, дээд үнэ 300 төгрөг байна. Өдрийн дундаж гүйлгээ нь 16,7 сая төгрөг, сарын дундаж гүйлгээ нь 79,3 сая төгрөг байлаа.